

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 11 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

Ду гаар	ХБТББ- т тусгагд сан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэг жих хуга цаа	Үндсэн хэрэг жүү лэгч байгуул лага	Эх үүсвэр	Нийт хөрөн гийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжил тийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төг)	Төсвийн гүйцэт гэл (сая төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	4.3.9. Гадаа дын иргэн, харьяа лалгүй хүний бүртгэл, мэдээ лэл, хянал тын тогтол цоог боловс ронгуй болгоно	2.Гадаадын иргэн, харьяалал гүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	2021- 2024	Хууль зүй, дотоод хэргийн яам	Улсын төсөв	772.0	-	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	100.0	0.0	“Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системийг нэвтрүүлэх арга хэмжээг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийн санхүүжилтээр ашиглалтад оруулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, И- Монгол академитай хамтран танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг уг системтэй 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс холбон үйлчилгээ үзүүлж эхэлсэн. “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нийт 636 удаагийн засвар,	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											<p>шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулан тайлант хугацаанд визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, гадаадын иргэний хаягийн бүртгэл, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлтэй холбоотой 47174 хүсэлтийг хүлээн авч, тус тус хянан шийдвэрлэлээ.</p> <p>Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлт" төслийн хүрээнд байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн. Системийн санхүүжилтийг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шийдвэрлэсэн бөгөөд 2024 онд хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.</p>	
Үнэлгээ: 100 хувь												

